

2022 он

**АШИГТ МАЛТМАЛЫН  
ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСӨЛД ХИЙСЭН  
ЗАРДЛЫН ТООЦООНЫ  
ТАЙЛАН**

Гүйцэтгэсэн: Ж.Уянга (PhD, эдийн засагч)

## **ЗАРДЛЫН ТООЦООНЫ АГУУЛГА**

1.ҮНДЭСЛЭЛ .....	2
2.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДАЛ .....	3
3.ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДАЛ.....	13
4.ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ .....	21
5.ТОВЧ ДҮГНЭЛТ.....	22

## **ХОЛБОГДОХ БУСАД**

БҮДҮҮВЧ 1.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫГ ТООЦОХ ДАРААЛАЛ

БҮДҮҮВЧ 2.ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫГ ТООЦОХ ДАРААЛАЛ

БҮДҮҮВЧ 3.ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫГ ТООЦОХ ДАРААЛАЛ

ХҮСНЭГТ 1.ХЯЛБАРЧЛАХ БОЛОМЖ

ХҮСНЭГТ 2.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ЗАДАРГАА

ХҮСНЭГТ 3.ХЯЛБАРЧЛАХ БОЛОМЖ

ХҮСНЭГТ 4.ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ЗАДАРГАА

ХҮСНЭГТ 5.ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ЗАДАРГАА

## **“АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

### **1.Үндэслэл**

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх шаардлага нь төслийн үр нөлөөг урьдчилан тандан судлах, хуулийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг тооцоолох болон холбогдох зардлын ачааллыг бууруулах боломж буй эсэхийг үнэлэх, санал боловсруулах үйл ажиллагаа багтсан. Уг аргачлалын 1.5 дахь хэсэгт зардлын тооцоог төрийн байгууллагын, хуулийн этгээдийн, болон иргэнд үүсэх гэсэн гурван төрлөөр тооцохоор тусгасан. Холбогдон гарах зардлыг бууруулах боломж байгаа эсэхийг мөн судалж, санал боловсруулсан.

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмалын эрэл, хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлэх, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, тогтвортой хөгжлийг хангах, геологи, уул уурхайн салбарын тогтолцоог бэхжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах зорилгоор боловсруулжээ. Хуулийн төслийн АРВАН ЗУРГАА ДУГААР БҮЛЭГ буюу ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ТОГТОЛЦОО бүлгийн 79.1 дэх зүйлд “Геологи, уул уурхайн салбар нь геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, геологийн судалгааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний харьяа орон нутаг дахь нэгж, уул уурхайн аврах алба, хөрөнгө оруулалтыг дэмжих зөвлөл, эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл, уул уурхайн судалгаа, хөгжлийн төвөөс бүрдэнэ.” гэж заасан.

Хуулийн төсөлд тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэхэд гарах зардлыг аргачлалын 1.5 дахь хэсэгт заасан үндсэн оролцогч нэг бүрээр тооцоолон гаргав. Энэхүү тооцоололд дээрх аргачлалд тусгасны дагуу дор дурдсан нийтлэг зарчмыг баримталсан. Үүнд:

- Төрийн байгууллага, хуулийн этгээд болон иргэд энэхүү хуулиар хүлээсэн үүргийг оновчтой тодорхойлох;
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлд энэхүү хуульд баримтлахаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан зарчмуудаас гадна ашигт малтмалыг эрэх, хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагаанд дараах зарчмуудыг баримтлахаар тусгасан. Үүнд:

- ашигт малтмалыг сорчлон ашиглахгүй байх;
- ил тод, нээлттэй, хариуцлагатай байх;
- ашигт малтмал төрийн хяналтад, төлбөртэй байх;
- ашигт малтмалын нөөцийг нэмэгдүүлж үр ашигтайгаар ашиглах;
- оролцогчдын хууль ёсны эрхийг хамгаалах;
- хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах.

Хуулийн төслийн зардлын тооцооллыг хийхдээ хуульд тусгагдсан чиг үүргийг гүйцэтгэхэд дээрхи зарчмуудыг алдагдуулахгүй байхыг зорьсон. Үндсэн оролцогчдод ногдох зардлыг одоогийн мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжийн зарим зүйл, заалтад нэмж туссан болон өөрчлөлт орсон тус бүрээр нь тоохон боловсруулсан. Бодит тоон мэдээлэл болон харгалзах хугацааг авч ашиглах боломжгүй үед аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн тохиолдлын тоо, үйл ажиллагааны зардлыг адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, бусад хуулийн тооцоолол болон холбогдох газраас мэдээллийг авч ашигласан.


## 2.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Ашигт малтмалын тухай хуулийг хэрэгжүүлэхэд Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагуудын энэхүү хуулиар хүлээлгэсэн чиг үүргүүдийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг тооцох шаардлагатай. Үүнд:

- Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,
- Геологийн судалгааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, болон
- Ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагууд тус тус хамаарна.

Ашигт малтмалын тухай хуульд заасан төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг хэрэгжүүлэхэд үүсэх зардлыг дээрх аргачлалын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Аргачлалд хууль тогтоомжийн зохицуулалтад хамааралтай төрийн байгууллага нэг бүрийг тодорхойлж, үйл ажиллагааны уялдаа хэрхэн хангагдаж байгааг тооцох шаардлагатайг тэмдэглэсэн.

Бүдүүвч 1.Төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцох дараалал



**Нэгдүгээр үе шатны хүрээнд:** байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлох – тухайн хууль тогтоомжид хамаарах (1) төрийн байгууллага, (2) тэдгээрийн гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг

тодорхойлно. Энэхүү хуулийн төсөлд төрийн байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой өргөн хүрээтэй чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан.

Энэ шатанд төрийн байгууллагыг сонгохдоо тухайн ажил, үйлчилгээнд хамааралтай бүх төрийн байгууллагыг биш зөвхөн голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгохоор аргачлалд тусгасан. Иймд хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг түүвэрлэн тодорхойлж, хэмжих боломжтой ажлыг хамааруулах нь зүйтэй гэж үзсэн.

**Хоёрдугаар үе шатны хүрээнд:** ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох – хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн ажил, үйлчилгээг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон нэг жилд гүйцэтгэх тоог нэг ажилтанд шаардагдах нийт ажлын цагийн хамт тооцож гаргана. Ийнхүү тооцохдоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид заасны дагуу захиргааны хэм хэмжээний акт боловсруулан баталж байгаа хугацааг жишиг болгон багцлан тооцлоо.

Гүйцэтгэх үүрэг тус бүрийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүнд зарцуулах хугацааг тодорхойлсны үндсэн дээр төрийн захиргааны төв байгууллагад үүсэх зардлын тооцооллыг Хүснэгт 2 харуулав. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэхүү хуулийн 80.1 дэх хэсэгт тусгасан 11 үүргийг гүйцэтгэхэд 738 000 минут буюу 12 300 цаг, харин төрийн захиргааны байгууллагууд хуулийн төслийн 81, 82, 83 болон 84 дэх зүйлд хэсэгт тусгасан холбогдох үүргүүдийг гүйцэтгэхэд 744 840 минут буюу 12 414 цаг тус тус зарцуулагдахаар байна. Төрийн байгууллагад үүсэн гарах нийт хугацаа нь 1 482 840 минут буюу 24 714 цаг зарцуулахаар байна. Энэхүү тооцооллод тухайн тоон хэмжүүрээр хэмжигдэх боломжтой ажил, үйлчилгээг гүйцэтгэхэд ажилтны тоо буюу нэмэгдэх ажлын ачааллыг хамгийн багадаа 13 хүн гүйцэтгэхээр байна.

**Гуравдугаар үе шатны хүрээнд:** гарах зардлыг урьдчилан тооцох – зардлын тооцоог хүний нөөцийн, материаллаг, болон бусад гэсэн зардлын бүрэлдэхүүн хэсэгт хувааж, тэдгээрийн нийлбэрийг гаргасны үндсэн дээр тодорхойлно.

Төрийн захиргааны байгууллагын хэмжигдэх боломжтой үүрэг тус бүрт тооцсон учраас энэхүү орон тоо үйл ажиллагаа өргөжихийн хирээр мөн энэ хуулийн хүрээнд бүрэн тусаагүй бусад дагалдах үүргийг гүйцэтгэхэд орон тоо нэмэх хэрэгцээг нөхцөлдүүлж болно. Тухайн чиг үүргийг шинээр ажилтан авч ажиллуулах болон одоо байгаа хүний нөөцийг ашиглан гүйцэтгэх эсэхийг шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна. Ажилтны нэг сарын дундаж цалинг 1 000 000 төгрөгөөр тооцвол тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд доод тал нь 13 хүн шаардлагатай гэсэн тооцооллыг гаргалаа.

Аргачлалд материаллаг зардал буюу тухайн ажлын байртай холбогдон гарах зардалд ажлын байрны түрээсийн төлбөр, эд хөрөнгийн элэгдэл хорогдол, цахилгаан дулаан, бичиг хэрэг, техник, тоног төхөөрөмж, урсгал болон хөрөнгө оруулалт зэргийг оруулахаар заасан. Энэхүү тооцооллыг хийхэд холбогдох хамгийн бодитой мэдээллийг Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын XVI дугаарт төрийн захиргааны төв байгууллагын их засварын ажилд 300.0 сая төгрөг,

салбарын тоног төхөөрөмжийн зардалд 850.6 сая төгрөгийг улсын төсвийн хөрөнгөөр<sup>1</sup> санхүүжүүлэхээр тусгасан байна.

**Дөрөвдүгээр үе шатны хүрээнд:** Энд нийт дүнг тооцоолох бөгөөд хүний нөөцийн зардал, материаллаг зардал, болон бусад зардлын нийлбэрээр нийт зардлыг тооцон гаргана.

Төрийн захиргааны төв байгууллагын хувьд өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа үүргүүд хэвээр үргэлжлэн явагдаж байгаа үед төрийн байгууллагад нэмэлтээр гарах зардал нийт 1 208.0 сая төгрөг байна. Үүнд 1 100.0 сая төгрөгийн материаллаг зардал болон цалингийн нэмэлт зардалд 156.0 сая төгрөг (13 хүн \*1.0 сая төгрөг = 13.0 сая төгрөг). Бусад зардлын хувьд өөр нэмэгдэл зардал шаардагдахгүй гэж үзэн, батлагдсан орон тоо, төсвөөр ажиллахаар тооцсон<sup>2</sup>. Нөгөө талаас төрийн байгууллагуудын олон төрлийн урсгал зардлууд цахим үндэстэн хөтөлбөрийн хүрээнд жил ирэх тутам буурах төсөөлөлтэй байгааг дурьдах хэрэгтэй.

**Тавдугаар үе шатны хүрээнд:** Хувилбарыг нягтлан хялбарчлах боломжийг шалгаж, үр дүнг танилцуулах ажлыг энэхүү үе шатанд хийж гүйцэтгэнэ. Төрийн байгууллагын зардлыг багасгах боломж бий эсэх, зохицуулалтын өөр хувилбар байгаа эсэх, ачаалал бууруулах боломжтой эсэхийг тогтоохыг зорьсон (Хүснэгт 1). Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн хэрэгжилтээс төрийн байгууллагуудад хүлээгдэж буй үр, өгөөж нь үүсэх зардалтай харьцуулахад өндөр байгааг тооцооллоос харж болно.

Хүснэгт 1.Хялбарчлах боломж

	Асуулга	Тайлбар
1.	Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх	Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахтай холбоотой төрийн байгууллага, хуулийн этгээд болон иргэний эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход хуулийн төсөлд тусгасан хуулийн этгээдийн тоог багасгах шаардлага байхгүй гэж үзэж байна.
2.	Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх	Мэдээллийг холбогдох газрууд тайлангийн хугацаандаа бэлтгэж байгаа мэдээллийг ил тод, үр өгөөжтэй болгох нь хуулийн төслийн үндсэн зорилт учраас давтамжийг багасгах шаардлагагүй гэж үзлээ. Цахим үндэстэн хөтөлбөрийн хүрээнд хуулийн этгээдүүд мэдээллийг хүргүүлэх, бэлтгэх зардал эрс буурна гэж үзсэн.
3.	Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх	Ашигт малтмалын тухай хууль заасан мэдээллийг тайлагнах нь нэг талаас нийгмийн хэрэгцээ шаардлага боловч нөгөө талаас хуулийн этгээдийн болон тухайн хуулийн этгээдийн нууцтай холбоотой “эмзэг” мэдээллийг тайлагнах нь эрсдэл үүсгэх эсэхэд анхаарах шаардлагатай.
4.	Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй	Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэх бүрэн боломжтой. Иймд шинээр нэмэгдэл зардал үүсэх үндэслэл эрс буурсан. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрх зүйн актын

<sup>1</sup> Бусад холбогдох зардлыг өөрийн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэх бөгөөд энэ тогтолцоо цаашид үргэлжилнэ гэж тооцсон.

<sup>2</sup> Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зардлын тооцоог хийхэд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуульд тусгагдсан үүргүүдтэй ижил байхаар тусгасан үед тухайн байгууллагад нэмэлтээр зардал тооцох шаардагдахгүй гэж үзэн, батлагдсан орон тоо, төсвөөр ажиллахаар тооцооллолд тусгах нийтлэг аргачлал бий.

	нэгтгэж болох эсэх	хүрээнд хийгдэж буй үйл ажиллагааны өгөөж энэхүү шинэчилсэн найруулгын хүрээнд шинэ түвшинд хүрч, нэмэгдэнэ гэж үзсэн.
5.	Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх	Мэдээллийг цахимаар хүргүүлэх бүрэн боломжтой. Цахим үндэстэн хөтөлбөрийн хүрээнд төрийн байгууллага, хуулийн этгээдүүд болон иргэд мэдээллийг хүргүүлэх, бэлтгэх зардал эрс буурна гэж үзэж байна.
6.	Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх	Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах шаардлага байхгүй гэж үзсэн. Цахим үндэстэн хөтөлбөрийн хүрээнд хуулийн этгээдүүд мэдээллийг хүргүүлэх, бэлтгэх зардал буурна гэж үзэж байгаа учраас байгууллагын тоог бууруулах бус харин мэдээллийн агуулгын баяжуулах шаардлагатай.
7.	Нэг цэгийн үйлчилгээ бий болгох боломжтой эсэх	Мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан ил тод байдлыг улам нэмэгдүүлэх. Цахим үндэстэн хөтөлбөрийн хүрээнд нэг цэгийн үйлчилгээ бий болгох боломжтой бүрэн үүссэн. Дижитал дэд бүтэц, цахим засаглал, мэдээллийн аюулгүй байдал, тоон бичиг үсгийн системийг үе шаттайгаар нэвтрүүлснээр холбогдон гаран зардал оролцогч бүх талуудад эрс буурна гэж үзэж байна.

Хүснэгт 2.Төрийн байгууллагад үүсэх зардлын задаргаа

Төрийн байгууллага	Хуулийн төсөлд хамаарах зүйл, заалт	Хэрэгжүүлэх чиг үүрэг	Тохиолдол тоогоор /өдрөөр жилд хийх давтамж/	Зарцуулах хугацаа /минут/	Нийт зарцуулах хугацаа /минут/
<b>1.Төрийн захиргааны төв байгууллага</b>					
<b>1.1.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн</b>	Хуулийн төслийн 80.1 дүгээр зүйлд заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлэх (80.1.1-80.1.11)	80.1.1.геологи, уул уурхайн салбарын талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг боловсруулах;	Зардал тооцох шаардлагагүй <sup>3</sup>		
		80.1.2.ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг бодлогын удирдамжаар хангах;	250	240	60 000
		80.1.3.уурхай, үйлдвэрийн хаалтын санхүүгийн баталгааг бүртгэх, түүний бүрдүүлэлт болон зарцуулалтад хяналт тавих;	200	480	96 000
		80.1.4.геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	200	300	60 000
		80.1.5.төрийн үйлчилгээг байнга сайжруулж, цахимжуулах;	200	300	60 000
		80.1.6.геологи, уул уурхайн салбарын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийж санал, дүгнэлт боловсруулж шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх;	250	480	120 000
		80.1.7.харьяа байгууллагынхаа үйл ажиллагаанд хяналт тавих;	250	300	75 000
		80.1.8.улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын талбай, төлөвлөгөө, төсөл, төсвийг тодорхойлох, тодотгох, үр дүнгийн тайланг хүлээн авсан тухай шийдвэр гаргах;	250	480	120 000
		80.1.9.энэ хуульд заасан багц дүрэм, журам, заавар, маягт, аргачлалыг батлах;	250	300	75 000
		80.1.10.зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл олгох;	200	240	48 000
		80.1.11.хууль тогтоомжид заасан бусад эрх.	200	120	24 000
				2 250	3 240
<b>Нийт</b>				<b>738 000 минут</b>	

<sup>3</sup> Аргачлалын 4.4.6 дахь хэсэгт хууль тогтоомжийн төсөлтэй холбогдуулан шийдвэр гаргахад төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоо хийхэд оруулахгүй гэж заасан.



## 2.Төрийн захиргааны байгууллага

		Зардал тооцох шаардлагагүй <sup>4</sup>			
<b>2.1.Геологийн судалгааны асуудал хариуцсан</b>	Хуулийн төслийн 81 дүгээр зүйлд заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлэх (81.1, 81.2.1-81.2.15)	81.1.Геологийн судалгааны талаарх төрийн бодлогыг Газрын хэвлийн тухай хууль, энэ хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлнэ.			
		81.2.1.Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр геологийн зураглал, эрлийн ажил гүйцэтгэж, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, минерагений судалгаа, үнэлгээний ажил хийж эрдэс баялаг, ашигт малтмалын хэтийн төлөвийг тодорхойлох;	150	240	36 000
		81.2.2.улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын талбай сонгох, геологийн даалгавар боловсруулах, төлөвлөгөө, төсөл, төсвийг тодорхойлох, тодотгох, үр дүнгийн тайланг хянах, хүлээн авах;	200	480	96 000
		81.2.3.үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах, боловсруулах, нууцын зэрэглэлд хамааруулснаас бусад мэдээллээр сонирхсон этгээдэд үйлчилгээ үзүүлэх;	30	120	3 600
		81.2.4.ашигт малтмалын нөөц, түүний хөдөлгөөнийг улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэх, тэнцэл хөтлөх;	200	120	24 000
		81.2.5.энэ хуулийн 17, 18, 19 дүгээр зүйлд заасан үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавих;	150	240	36 000
		81.2.6.улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдсэн геологийн суурь судалгааны мэдээлэл, эрдэс баялаг, ашигт малтмалын хэтийн төлөвт үндэслэн эрлийн үйл ажиллагаа явуулах талбайн солбицлыг жил бүр тодорхойлох;	90	300	27 000
		81.2.7.энэ хуулийн 81.2.6-д заасан эрлийн үйл ажиллагаа явуулах талбайн ажлын даалгаврыг холбогдох журмын дагуу боловсруулж, хуулийн хүрээнд сонгон шалгаруулалтыг зарлаж, шалгарсан этгээдтэй гэрээ байгуулах;	60	480	28 800
		81.2.8.ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын болон өргөдлийн талбайн геологийн	90	180	16 200

<sup>4</sup> Аргачлалын 4.4.6 дахь хэсэгт хууль тогтоомжийн төсөлтэй холбогдуулан шийдвэр гаргахад төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоо хийхэд оруулахгүй гэж заасан.

		суурь судалгааны мэдээллийг бэлтгэх, талбай ялгах үндэслэл тодорхойлох;			
		81.2.9.энэ хуулийн хүрээнд өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх явцад бий болсон мэдээллийг 79.1-д заасан байгууллагууд болон олон нийтэд нээлттэй мэдээлэх;	200	60	12 000
		81.2.10.геологийн баримтын төв архив буюу төрийн төрөлжсөн архивыг хамаарч, түүний мэдээлэл бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалтыг хариуцах;	150	240	36 000
		81.2.11.эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургууль шинжлэх ухаан, танин мэдэхүй, сургалтын зорилгоор тойм судалгааг гүйцэтгэж болох бөгөөд энэ тухай геологийн судалгааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлэх;	150	240	36 000
		81.2.12.гадаад, дотоодын ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтран ажиллах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах, салбарын үйл ажиллагааг сурталчлах;	150	240	36 000
		81.2.13.Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн судалгааны ажлын явц, хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавих, зөвлөмж өгөх;	200	300	60 000
		81.2.14.Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажил, хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, анхдагч материалыг хүлээн авахаар гаргасан шийдвэрийг үндэслэн хүлээн авч бүртгэх, мэдээллийг санд оруулах;	150	240	36 000
		81.2.15.Геологи, уул уурхайн салбартай холбогдолтой төрөл бүрийн эрдэм шинжилгээний ажлын үр дүн, бүтээл, ном товхимол хүлээн авч мэдээллийн санд оруулах;	90	120	10 800
		<b>Нийт (2.1)</b>	<b>2 060</b>	<b>3 600</b>	<b>494 400</b>
		82.1.Ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь ашигт малтмалын талаарх төрийн бодлогыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ.	Зардал тооцох шаардлагагүй <sup>5</sup>		
		82.2.1.хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн зураг зүйн бүртгэл хөтлөх;	100	120	12 000

<sup>5</sup> Аргачлалын 4.4.6 дахь хэсэгт хууль тогтоомжийн төсөлтэй холбогдуулан шийдвэр гаргахад төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоо хийхэд оруулахгүй гэж заасан.

<b>2.2.Ашигт малтмалын асуудал хариуцсан</b>	Хуулийн төслийн 82 дугаар зүйлд заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлэх (82.1, 82.2.1-82.2.14)	82.2.2.хайгуул, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгох, хугацаа сунгах, нөхөн олгох;	100	120	12 000
		82.2.3.хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барьцаалах, олгогдсон талбайг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан өгөх ажиллагааг бүртгэх;	100	120	12 000
		82.2.4.үйлчилгээний хөлс, тусгай зөвшөөрлийн төлбөрийг бүртгэх;	100	90	9 000
		82.2.5.тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд үүссэн тусгай зөвшөөрлийн талбайн хилийн маргааны шийдвэрлэх;	60	240	14 400
		82.2.6.энэ хуулийн 14.1.3, 14.1.4, 14.1.6-д заасан талбайн солбицлыг орон нутагт мэдэгдэх;	100	60	6 000
		82.2.7.энэ хуулийн 81.2.8-д заасан мэдээлэлд тулгуурлан тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын болон өргөдлийн талбайг ялгаж бэлтгэх;	100	240	24 000
		82.2.8.сонирхсон этгээдэд тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлтэй танилцуулах, эдгээр бүртгэлд орсон өөрчлөлтийн талаар холбогдох төрийн байгууллагад мэдэгдэж нийтэд мэдээлэх;	12	120	1 440
		82.2.9.бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талбайн солбицлыг тодорхойлж, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;	60	480	28 800
		82.2.10.хайгуул, ашиглалт, баяжуулалтын мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах;	200	120	24 000
		82.2.11.уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийг судалж, хэтийн төлөвийг тодорхойлох;	90	120	10 800
		82.2.12.ордын нөөцийн хөдөлгөөний бүртгэл хөтлөх;	200	60	12 000
		82.2.13.ашигт малтмал баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, цуцлах асуудлыг шийдвэрлэх, бүртгэл хөтлөх;	200	240	48 000
		82.2.14.хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл хүчингүй болсон, хугацаа дуусгавар болсон тохиолдолд хайгуулын ажлын анхдагч тоон өгөгдлийг тайлан, хайгуулын үр дүнгийн тайлангийн хамт геологийн судалгааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тушаах.	100	120	12 000
		<b>Нийт (2.2)</b>		<b>1 522</b>	<b>2 250</b>

<b>2.3. Аймаг, нийслэл дэх геологи, уул уурхайн асуудал хариуцсан нэгж</b>	Хуулийн төслийн 83 дугаар зүйлд заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлэх (83.1-83.2)	83.1. Ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын харьяанд аймаг, нийслэл дэх геологи, уул уурхайн асуудал хариуцсан нэгж нь геологи, уул уурхайн салбарын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутагт хангах, сурталчлан таниулах, хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэдэд үйлчлэх, төрийн болон орон нутгийн төрийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.	Зардал тооцох шаардлагагүй <sup>6</sup>		
		83.2. Аймаг, нийслэл дэх геологи, уул уурхайн асуудал хариуцсан нэгжийн даргыг геологи, уул уурхайн салбарт 5-аас доошгүй жил ажилласан, төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөж ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага томилно.			
<b>2.4. Авран хамгаалах алба</b>	Хуулийн төслийн 84 дүгээр зүйлд заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлэх (84.1-84.6)	84.1. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тохиолдож болзошгүй үйлдвэрлэлийн аюул ослоос урьдчилан сэргийлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх, аюул ослын холбогдолтой төлөвлөлтэд оролцох, сургалт зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг хангах, аюул осол үүссэн үед хүмүүсийг аврах, түүний үр дагаварыг арилгах, аврах нэгжийг мэргэжлийн удирдлагаар хангах үүрэг бүхий Уул уурхайн аврах албатай байна.	Зардал тооцох шаардлагагүй <sup>7</sup>		
		84.2. Энэ хуулийн 8.3-д заасан уурхай нь дэргэдээ сайн дурын аврах нэгжтэй байж болно.			
		84.3. Уурхай, баяжуулах үйлдвэрт аюул осол үүссэн үед нутгийн захиргааны байгууллага, түүнчлэн аж ахуйн нэгж, байгууллага харьяалал харгалзахгүйгээр тээврийн хэрэгсэл, материал, тоног төхөөрөмж, эм, эмчилгээний эд зүйл олгох, холбооны хэрэгслээр үйлчлэх, аюул ослын үр дагаварыг арилгахад шаардагдах бүх төрлийн тусламж үзүүлэх үүрэгтэй.	50	480	24 000
		84.4. Уурхай, баяжуулах үйлдвэр тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага өөрийн харьяа уурхай, үйлдвэрийн			

<sup>6</sup> Аргачлалын 4.4.6 дахь хэсэгт хууль тогтоомжийн төсөлтэй холбогдуулан шийдвэр гаргахад төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоо хийхэд оруулахгүй гэж заасан.

<sup>7</sup> Аргачлалын 4.4.6 дахь хэсэгт хууль тогтоомжийн төсөлтэй холбогдуулан шийдвэр гаргахад төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоо хийхэд оруулахгүй гэж заасан.

		аврах нэгжийн дүрэм, аврах үйл ажиллагааны журмыг Уул уурхайн аврах албаар хянуулж зөвшөөрүүлсэн байна.	Зардал тооцох шаардлагагүй <sup>8</sup>
		84.5.Уул уурхайн аврах албаны ажилтныг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.17-д заасантай дүйцүүлэн ойлгоно.	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.17-д "мэргэжлийн анги" гэж сум, дүүрэг, хуулийн этгээдийн дэргэд байгуулагдсан, аврах ажлын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдсан, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг гүйцэтгэхэд сургаж бэлтгэгдсэн орон тооны бус томилгоот нэгжийг байхаар заасан нь цалингийн зардал нэмж тооцох шаардлагагүй.
		84.6.Уул уурхайн аврах албаны албан хаагчид тавигдах шаардлага, эрх, үүрэг, албан хаагчийн үүргээ биелүүлэх баталгаа, тэтгэвэр, тэтгэмжийн асуудлыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар бүлгийн 30, 31, 33, 34 дүгээр зүйлд заасантай дүйцүүлэн геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохицуулна.	Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын жилийн төсөвт тусах учраас тусгайлан тооцоолох шаардлагагүй.
<b>Нийт</b>			<b>744 840 минут</b>
<b>НИЙТ ШААРДАГДАХ ХУГАЦАА</b>			<b>1 482 840 минут</b>

<sup>8</sup> Аргачлалын 4.4.6 дахь хэсэгт хууль тогтоомжийн төсөлтэй холбогдуулан шийдвэр гаргахад төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоо хийхэд оруулахгүй гэж заасан.

### 3.ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцох аргачлалд тусгаснаар хуулийн этгээдийн зардал нь тухайн хууль тогтоомжоор төрийн байгууллагаас бусад аж ахуйн нэгж, байгууллагад хүлээлгэж байгаа үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулж байгаа мөнгөн зардал байхаар тусгасан.

Аргачлалын 2.3 дахь хэсэгт гүйцэтгэх үүрэг гэж тухайн хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд хуульд заасны дагуу тоо, баримт, тайлан, холбогдох бусад мэдээллийг бэлтгэн төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд гаргаж өгөх, эсхүл хүргүүлэхийг заасан. Үүнд бүх төрлийн өргөдөл, хүсэлт, маягт бөглөх, статистик тоо мэдээ өгөх, бүртгүүлэх, нөхөн олговор, төрөөс тусламж, дэмждэг, зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл гаргах, зөвшөөрөл хүсэх гэх мэт үүргүүдийг хамааруулж ойлгоно.

Хуулийн төсөлд тусгасны дагуу зардлыг тооцох ажлыг дараах үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн:

1. Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
2. Зардлыг тооцох;
3. Тоон үзүүлэлтийг тооцох;
4. Нийт зардлын дүнг тооцож гаргах;
5. Хялбарчлах боломжийг шалгах;
6. Нэмэлт зардлыг тооцох.

**Нэгдүгээр үе шатны хүрээнд:** хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдүүдийн хүлээх үүргийг Хүснэгт 4 тодорхойлсон.


Хуулийн төсөлд тусгагдсан хуулийн этгээдүүд:

- Геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтыг дэмжих зөвлөл
- Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл
- Уул уурхайн судалгаа, хөгжлийн төв
- Мэргэжлийн холбоо, мэргэшсэн мэргэжилтэн
- Геологи, уул уурхайн салбарын олон нийтийн боловсрол
- Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч тус тус багтана.

**Хоёрдугаар үе шатны хүрээнд:** гүйцэтгэх үүрэг тус бүрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүнд зарцуулах хугацааг тодорхойлсны үндсэн дээр нэг хуулийн этгээдэд үүсэх мөнгөн зардлыг тооцов. Түүнчлэн, хуулийн этгээдийн үүргийн гүйцэтгэлийг хэмжих боломжтой ажлыг хамааруулдаг. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн этгээдийн хувьд хууль, тогтоомжид заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан дараах 2 төрлийн мөнгөн зардлыг тооцно.

1. Төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага хуулийн төсөлд тусгасан үүргээ гүйцэтгэхэд холбоотой гарах зардал,
2. Бусад хуулийн этгээдийн хуулийн төсөлд тусгасан үүргээ гүйцэтгэхэд холбоотой гарах зардал.

## Бүдүүвч 2.Хуулийн этгээдэд үүсэх зардлыг тооцох дараалал<sup>9</sup>



**Гуравдугаар үе шатны хүрээнд:** зардлын тооцоог хүний нөөцийн болон бусад гэсэн зардлын бүрэлдэхүүн хэсэгт хувааж, тэдгээрийн нийлбэрийг гаргасны үндсэн дээр тодорхойлов. Хуулийн этгээд хуанлийн 1 жилийн хугацаанд тухайн үүргийг хэдэн удаа давтан хэрэгжүүлэхээс хамаарч, тохиолдол буюу давталтын тоог 1 – 12 удаа байхаар тооцсон.

**Дөрөвдүгээр үе шатны хүрээнд:** нийт зардлын дүнг тооцох үе шатанд зардлын нийт дүнг тооцож гаргадаг. Ингэж тооцохдоо тухайн үүргийг гүйцэтгэхэд шаардагдах зардлыг тоон үзүүлэлтээр үржүүлж гаргасан. Хуулийн төсөлд ажил, үйлчилгээ үзүүлэхээр тусгагдсан хуулийн этгээдүүдийн зардлыг Геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтыг дэмжих зөвлөл, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл, Уул уурхайн судалгаа, хөгжлийн төв, Мэргэжлийн холбоо, Геологи, уул уурхайн салбарын олон нийтийн боловсрол, болон Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч гэсэн хуулийн этгээдүүдэд тооцоолоход одоогийн орон тоо, зардлын төсөв дээр нэмэгдэж 555.0 сая төгрөгийн зардал гарахаар тооцоо гарч байна.

**Тавдугаар үе шатны хүрээнд:** энэ шатанд хялбарчлах боломжийг шалгадаг бөгөөд өмнөх үе шатанд тодорхойлсон хэмжигдэх боломжтой үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг дараах асуулгаар тодруулж гүйцэтгэлээ. Аргачлалын 2.7 дахь хэсэгт тусгасан хялбарчлах боломжийг шалгах үе шатыг дараах Хүснэгт 3 харуулсан.

### Хүснэгт 3.Хялбарчлах боломж

	Асуулга	Тайлбар
1.	Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх	Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахтай холбоотой төрийн байгууллага, хуулийн этгээд болон иргэний эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход хуулийн төсөлд тусгасан хуулийн этгээдийн тоог багасгах шаардлага байхгүй гэж үзэж байна.

<sup>9</sup> Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын Хүснэгт 3.

2.	Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх	Мэдээллийг холбогдох газрууд тайлангийн хугацаандаа бэлтгэж байгаа мэдээллийг ил тод, үр өгөөжтэй болгох нь хуулийн төслийн үндсэн зорилт учраас давтамжийг багасгах шаардлагагүй гэж үзлээ. Цахим үндэстэн хөтөлбөрийн хүрээнд хуулийн этгээдүүд мэдээллийг хүргүүлэх, бэлтгэх зардал эрс буурна гэж үзсэн.
3.	Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх	Ашигт малтмалын тухай хууль заасан мэдээллийг тайлагнах нь нэг талаас нийгмийн хэрэгцээ шаардлага боловч нөгөө талаас хуулийн этгээдийн болон тухайн хуулийн этгээдийн нууцтай холбоотой “эмзэг” мэдээллийг тайлагнах нь эрсдэл үүсгэх эсэхэд анхаарах шаардлагатай.
4.	Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх	Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэх бүрэн боломжтой. Иймд шинээр нэмэгдэл зардал үүсэх үндэслэл эрс буурсан. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрх зүйн актын хүрээнд хийгдэж буй үйл ажиллагааны өгөөж энэхүү шинэчилсэн найруулгын хүрээнд шинэ түвшинд хүрч, нэмэгдэнэ гэж үзсэн.
5.	Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх	Мэдээллийг цахимаар хүргүүлэх бүрэн боломжтой. Цахим үндэстэн хөтөлбөрийн хүрээнд төрийн байгууллага, хуулийн этгээдүүд болон иргэд мэдээллийг хүргүүлэх, бэлтгэх зардал эрс буурна гэж үзэж байна.
6.	Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх	Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах шаардлага байхгүй гэж үзсэн. Цахим үндэстэн хөтөлбөрийн хүрээнд хуулийн этгээдүүд мэдээллийг хүргүүлэх, бэлтгэх зардал буурна гэж үзэж байгаа учраас байгууллагын тоог бууруулах бус харин мэдээллийн агуулгын баяжуулах шаардлагатай.
7.	Нэг цэгийн үйлчилгээ бий болгох боломжтой эсэх	Мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан ил тод байдлыг улам нэмэгдүүлэх. Цахим үндэстэн хөтөлбөрийн хүрээнд нэг цэгийн үйлчилгээ бий болгох боломжтой бүрэн үүссэн. Дижитал дэд бүтэц, цахим засаглал, мэдээллийн аюулгүй байдал, тоон бичиг үсгийн системийг үе шаттайгаар нэвтрүүлснээр холбогдон гаран зардал оролцогч бүх талуудад эрс буурна гэж үзэж байна.



Хүснэгт 4. Хуулийн этгээдэд үүсэх зардлын задаргаа

Хуулийн этгээд	Хуулийн төсөлд хамаарах зүйл, заалт	Хэрэгжүүлэх чиг үүрэг	Тохиолдол тоогоор /өдрөөр жилд хийх давтамж/	Зарцуулах хугацаа /минут/	Нийт зарцуулах хугацаа /минут/
<b>3.Хуулийн этгээд</b>					
<b>3.1.Геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтыг дэмжих зөвлөл</b>	Хуулийн төслийн 85.1 дүгээр зүйлд заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлэх (85.1-85.5)	85.1.Геологи, уул уурхайн салбарын хөгжлийг дэмжих, салбарын татвар, хөрөнгө оруулалтын орчин, өрсөлдөх чадварыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих орон тооны бус зөвлөлийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байгуулж ажиллуулна.	Олон тооны бус байхаар хуулийн төсөлд тусгасан тул тусгайлан зардал тооцох шаардлагагүй гэж үзсэн. Холбогдох зардлыг нэмэгдэл зардалд шингээн тооцох боломжтой юм.		
		85.2.Энэ хуулийн 85.1-д заасан зөвлөл нь төрийн болон хөрөнгө оруулагчдын төлөөллөөс бүрдсэн 9 хүртэлх гишүүнтэй байх ба тус зөвлөлийг талууд ээлжилж даргална			
		85.3.Хөрөнгө оруулалтыг дэмжих зөвлөл нь байгаль орчин, нийгэм, засаглалын болон хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах асуудал хариуцсан хороодтой байж болох бөгөөд хороодын гишүүдэд хүний эрх, байгаль орчин, орон нутаг, засаглал, иргэний нийгэм, салбарын мэргэжлийн холбоод болон эрдэм шинжилгээний байгууллагын төлөөллийн оролцоог тэгш хангасан байна.			
		85.4.Хөрөнгө оруулалтыг дэмжих зөвлөл, түүний хороодын бүрэлдэхүүн, ажиллах журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.			
		85.5.Хөрөнгө оруулалтыг дэмжих зөвлөлийн үйл ажиллагааны хуулиар нууцад хамааруулснаас бусад мэдээлэл олон нийтэд ил тод байна.			
		86.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдсэн геологийн судалгааны ажлын үр дүнгийн тайлан, хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, ашигт малтмал ашиглах болон баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд	Зардал тооцох шаардлагагүй <sup>11</sup>		

<sup>11</sup> Аргачлалын 4.4.6 дахь хэсэгт хууль тогтоомжийн төсөлтэй холбогдуулан шийдвэр гаргахад төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоо хийхэд оруулахгүй гэж заасан.

<b>3.2.Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл<sup>10</sup></b>	Хуулийн төслийн 86 дугаар зүйлд заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлэх (86.1-86.7)	дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл ажиллана.	
		86.2.1.улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны үр дүнгийн тайланг хэлэлцэх дэд зөвлөл.	Энэ үйл ажиллагааг гүйцэтгэх үүрэг бүхий бүтцийн хүрээнд зардал тооцогдох тул нэмэлт зардал гарахгүй.
		86.2.2.хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, олборлолт, баяжуулалтын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг хэлэлцэх дэд зөвлөл.	Үндсэн ажлын нэг хэсэгт хамаарч тооцогдох учир тусдаа цалингийн зардал гарахгүй.
		86.3.1.улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны үр дүнгийн тайланг хэлэлцэх дэд зөвлөл нь геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, геологийн судалгааны болон ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагууд, салбарын эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын байгууллагын төлөөлөл-9 гишүүн;	Нийт цалингийн зардал = 108 000 000 төгрөг <sup>12</sup>
		86.3.2.хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, ашиглалт, баяжуулалтын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, уурхайн хаалтын төлөвлөгөөг хэлэлцэх дэд зөвлөл нь геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөл-17 гишүүн.	Нийт цалингийн зардал = 204 000 000 төгрөг
		86.4.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 86.2-т заасан дэд зөвлөлийн даргыг томилно.	Тоон хэмжүүрээр хэмжигдэх боломжгүй үйл ажиллагаануудад хамаарна.
		86.5.Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл нь хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэл, техникийн зураг төсөлд дүгнэлт, шүүмж гаргах мэргэшсэн шинжээчийг томилон ажиллуулна.	Нийт цалингийн зардал = 12 000 000 төгрөг

<sup>10</sup> 86.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдсэн геологийн судалгааны ажлын үр дүнгийн тайлан, хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, ашигт малтмал ашиглах болон баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл ажиллана.

<sup>12</sup> Цалингийн зардлын задаргаа: 12 сар \*9 000 000 төгрөг = 108 000 000 төгрөг, 9 хүн \*1 000 000 төгрөг (цалингийн зардал) = 9 000 000 төгрөг

		86.6.Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Тоон хэмжүүрээр хэмжигдэх боломжгүй үйл ажиллагаанд хамаарна.
		86.7.Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааны хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад мэдээлэл, мэргэшсэн шинжээчдийн мэдээлэл олон нийтэд ил тод байна.	
<b>3.3.Уул уурхайн судалгаа, хөгжлийн төв</b> <sup>13</sup>	Хуулийн төслийн 87 дугаар зүйлд заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлэх (87.2.1-87.2.5)	87.2.1.уул уурхайн салбарын хөгжлийн тухайн үеийн нөхцөл байдал, хэтийн төлөв, олон улсын чиг хандлагын талаарх суурь судалгаа, дүн шинжилгээ хийж салбарын бодлогыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх;	Зардал тооцох шаардлагагүй <sup>14</sup>
		87.2.2.уул уурхайн бүтээгдэхүүний зах зээл, үнэ ханш, эрэлт, нийлүүлэлтийн талаар судалгаа хийж, санал, дүгнэлт гаргах <sup>15</sup> ;	Нийт цалингийн зардал = 24 000 000 төгрөг
		87.2.3.уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчинд үнэлэлт, дүгнэлт өгөх, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	Тоон хэмжүүрээр хэмжигдэх боломжгүй үйл ажиллагаануудад хамаарна. Эдгээр үүргүүд нь мөн хуулийн 87.2.1 болон 87.2.2 заалтад тус тус тодорхойлсон салбарын бодлогыг гаргах судалгаа шинжилгээний үүргийн хүрээнд хамаарагдана байгаа гэж ойлгогдохоор байна. Иймд нэмэлт зардал болгон тооцох шаардлагагүй.
		87.2.4.цахим шилжилт, техник, технологи, инновац, хүний нөөцийн эрэлт, хэрэгцээнд тулгуурласан бүтээмжийг нэмэгдүүлэх цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх;	
		87.2.5.ус, эрчим хүчний хэмнэлт, дэд бүтцийн хөгжлийн оновчтой шийдэл, олон улсын хөгжлийн чиг хандлагын талаарх төлөвийг тодорхойлж, санал, дүгнэлт боловсруулах.	
<b>3.4.Мэргэжлийн холбоо</b> <sup>16</sup>	Хуулийн төслийн 88 дугаар зүйлд заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлэх	88.4.1.мэргэшсэн мэргэжилтний эрх олгох, үргэлжилсэн сургалт зохион байгуулах;	Нийт цалингийн зардал = 15 000 000 төгрөг
		88.4.2.мэргэшсэн мэргэжилтэн, технологийн аудитор, хөрөнгийн үнэлгээчний ёс зүйн дүрмийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;	Тоон хэмжүүрээр хэмжигдэх боломжгүй үйл ажиллагаанд хамаарна.
		88.4.3.үндэсний стандарт боловсруулах, хэрэглээний тайлбар, аргачилсан зөвлөмж, гарын авлага боловсруулан гаргах;	10 000 000 төгрөг

<sup>13</sup> 87.1.Уул уурхайн судалгаа, хөгжлийн төв нь хариуцлагатай, тогтвортой уул уурхайн хөгжлийн талаарх төрийн бодлого, стратеги, техник, технологи, инновацын хөгжил, ус, эрчим хүчний хэмнэлт, түүнчлэн геологи, уул уурхайн салбарын үр өгөөж, бүтээмжийг нэмэгдүүлэх, олон улсад өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэсэн цогц судалгаа, дүн шинжилгээ хийх, санал зөвлөмж боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

<sup>14</sup> Аргачлалын 4.4.6 дахь хэсэгт хууль тогтоомжийн төсөлтэй холбогдуулан шийдвэр гаргахад төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоо хийхэд оруулахгүй гэж заасан.

<sup>15</sup> 2 хүний цалингийн зардал гарна гэж тооцсон.

<sup>16</sup> 88.1.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь аудитор, маркшейдер, хөрөнгийн үнэлгээ хийх мэргэшсэн мэргэжилтнийг баталгаажуулах, тэдгээрт эрх олгох, сунгах, цуцлах чиг үүргийг гэрээний үндсэн дээр мэргэжлийн холбоогоор гүйцэтгүүлж болно.

	(88.4.1-88.4.5)	88.4.4.хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагааг арга зүйн удирдлага, зөвлөгөө мэдээллээр хангах; 88.4.5.тухайн мэргэжлийн үйл ажиллагааны стандарт, мэргэжлийн ёс зүйн дүрмийг зөрчсөн мэргэшсэн мэргэжилтний эрхийг хүчингүй болгох.	24 000 000 төгрөг Тоон хэмжүүрээр хэмжигдэх боломжгүй үйл ажиллагаанд хамаарна.
<b>3.5.Геологи, уул уурхайн салбарын олон нийтийн боловсрол</b>	Хуулийн төслийн 89 дүгээр зүйлд заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлэх (89.1-89.3)	89.1.Засгийн газар албан болон албан бус тогтолцооны хүрээнд иргэдэд геологи, уул уурхайн салбарын боловсрол олгох хөтөлбөрийг баталж, хэрэгжилтийг дараах байдлаар зохион байгуулна: 89.1.1.ерөнхий боловсролын сургуульд хэрэглэх геологи, уул уурхайн салбарын анхны мэдлэг олгох сургалтын материал бэлтгэж, санал болгох <sup>17</sup> ;	Нийт цалингийн зардал = 36 000 000 төгрөг
		89.1.2.геологи, уул уурхайн бус чиглэлийн коллеж, их, дээд сургууль болон мэргэжлийн сургалтын байгууллагад геологи, уул уурхайн салбарын шинжлэх ухааны үндэс, техник, технологи, арга зүйн мэдлэг олгох сургалтын материал бэлтгэж, санал болгох <sup>18</sup> .	Нийт цалингийн зардал = 36 000 000 төгрөг
		89.2.Аймаг, нийслэл дэх геологи, уул уурхайн асуудал хариуцсан нэгж нь нутгийн захиргааны байгууллага, тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдэд геологи, уул уурхайн салбарын талаар мэдээллийг хүргэх, сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулна.	Нийт цалингийн зардал = 12 000 000 төгрөг
		89.3.Геологи, уул уурхайн салбарын төрийн болон төрийн бус байгууллага геологи, уул уурхайн салбарын хууль тогтоомж, хөгжлийн чиг хандлагыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчилна.	Зардал =50 000 000 төгрөг

<sup>17</sup> Сургалтын материал бэлтгэгч, сургагч багшийн сарын цалинг 1 500 000 төгрөгөөр тооцож, 2 хүний цалингийн зардал гарна гэж үзсэн.

<sup>18</sup> Сургалтын материал бэлтгэгч, сургагч багшийн сарын цалинг 1 500 000 төгрөгөөр тооцож, 2 хүний цалингийн зардал гарна гэж үзсэн.

<b>3.6.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч<sup>19</sup></b>	Хуулийн төслийн 24 дүгээр зүйлд заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлэх	Хуулийн төслийн 24.2.1 - 24.2.12 заалтууд	Тоон хэмжүүрээр хэмжигдэх боломжгүй үйл ажиллагаанд хамаарна.
		24.2.13.ашигт малтмалын ордын нөөцийг тогтоох зорилгоор геологийн судалгааг иж бүрэн хийж гүйцэтгэх <sup>20</sup> ;	24 000 000 төгрөг
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>			<b>555 000 000 төгрөг</b>


<sup>19</sup> Хуулийн төслийн 12.1 дэх хэсэгт Хайгуулын тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, мэргэжлийн хүний нөөцтэй, татвар төлөгч хуулийн этгээдэд энэ хуульд заасан журмын дагуу олгоно.

<sup>20</sup> 2 ажилтны цалингийн зардал.

## 4.ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Иргэнд үүсэх холбогдох зардал, ачааллыг тооцох ажлыг аргачлалын 4 дүгээр хавсралтын 3.1 дэх хэсэгт заасан 5 үе шатаар тооцоолно.

Бүдүүвч 3.Иргэнд үүсэх зардлыг тооцох дараалал



Хуулийн төслийн 93.4 дэх хэсэгт “Иргэн, байгууллага, хуулийн этгээд нь шинжлэх ухаан, технологийн сан, олон улсын болон гадаадын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн хүрээнд бүрдүүлсэн геологи, уул уурхайн мэдээллийг геологи, эрдэс баялгийн мэдээллийн санд үнэ төлбөргүй төвлөрүүлэх үүрэгтэй” байхаар тусгажээ.Төсөлд иргэнд үүсэх өөр төрлийн зардал гарахгүй байхаар тусгасан байна.

**Нэгдүгээр үе шатны хүрээнд:** иргэний гүйцэтгэх үүргийг Хүснэгт 5 харуулав. Мөнгөн зардлыг тооцохдоо тухайн үүргийг хэрэгжүүлэхэд иргэнээс зайлшгүй гарах мөнгөн зардал буюу бодит, тогтсон зардлыг тооцно. Мэдээллийг холбогдох газарт хүргүүлэхэд гарах бичиг хэрэг, шуудангийн зардал, баримт бичгийг нотаратаар баталгаажуулахыг тухайлан шаардсан тохиолдолд нотаратын зардал, гадаад паспорт авах өргөдөл гаргахад цээж зураг авахуулах зардал, зөвшөөрөл хүсэхэд төлөх хураамж зэргийг тооцоололд тусгахаар заасан.

**Хоёрдугаар үе шатны хүрээнд:** хуулийн төслийн 93.2 дугаар хэсэгт мэдээллийн санд мэдээлэл бүрдүүлэхэд үүрэг хэрэгжүүлэх байгууллага, хугацааг тусгасан. Тус зүйлийн 93.4 дахь хэсэгт иргэн, байгууллага, хуулийн этгээд нь шинжлэх ухаан, технологийн сан, олон улсын болон гадаадын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн хүрээнд бүрдүүлсэн геологи, уул уурхайн мэдээллийг геологи, эрдэс баялгийн мэдээллийн санд үнэ төлбөргүй төвлөрүүлэх үүрэгтэй байхаар заасан байна. Энэхүү үүргийг жилд гүйцэтгэх тохиолдол болон давтамжийг тодорхойлох боломжгүй юм. Түүнчлэн, хуулийн төсөлд тодорхойлсончлон иргэн дотоодын болон гадаадын санхүүгийн эх үүсвэрийн хүрээнд бүрдүүлсэн мэдээлэл гэсэн нь зардал тооцох журамд заасан шалгуурыг хангах боломжгүй. Энэхүү үйл ажиллагаа нь

иргэн, хуулийн этгээдэд хир хэмжээний зардлаар энэхүү мэдээлэлтэй болж байгаа нь “хэмжигдэх боломжгүй<sup>21</sup>” юм.

**Гуравдугаар үе шатны хүрээнд:** хуулийн төслийн 93.4 дэх хэсэгт иргэн, байгууллага, хуулийн этгээд нь шинжлэх ухаан, технологийн сан, олон улсын болон гадаадын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн хүрээнд бүрдүүлсэн геологи, уул уурхайн мэдээллийг геологи, эрдэс баялгийн мэдээллийн санд үнэ төлбөргүй төвлөрүүлэх үүрэг хүлээлгэсэн байгаа нь хэмжигдэх боломжгүй юм. Иймд энэхүү хуулийн төслийг хэрэгжүүлэхэд төсөлд тусгасан үүрэг, үйл ажиллагаанууд нь иргэнд “бодитой зардал” гаргахгүй болохыг харуулж байна.

**Дөрөвдүгээр болон тавдугаар үе шатны хүрээнд:** хуулийн төсөлд тусгагдсан иргэнийн гүйцэтгэх үйл ажиллагаатай холбоотой нэмэгдэл зардал гарахгүй байгаа учраас зардлыг хялбарчлах шаардлагагүй юм.

## 5.ТОВЧ ДҮГНЭЛТ

Хуулийн төслийн хүрээнд төрийн захиргааны байгууллага болон хуулийн этгээдээс гарах зардлын суурь зориулалт нь газрын хэвлийн баялаг буюу ашигт малтмалыг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлан ашиглах, түүний үр өгөөжийг нэмэгдүүлэх, ашигт малтмалын эрэл, хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлэх, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, тогтвортой хөгжлийг хангах, геологи, уул уурхайн салбарын тогтолцоог бэхжүүлэх хуулийн үндсэн зорилгыг хангахад чиглэгдэнэ.

Энэхүү зорилтыг хангахад дараах өргөн хүрээтэй зорилтуудыг хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд:

- ашигт малтмал эрэх, хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагааны зарчмыг тодорхойлох,
- ашигт малтмал хайх, олборлох, баяжуулах эрх олгох болон энэхүү эрхтэй холбоотой бусад харилцааны үндэслэл, шаардлага, нөхцөл, журмыг тогтоох,
- геологи, уул уурхайн салбар дахь төрийн зохицуулалт тодорхойлох,
- геологийн судалгаа, хайгуул, олборлолт, баяжуулалт, уурхай, үйлдвэрийн хаалттай холбоотой үйл ажиллагааны зохицуулалт, нөхцөл, журмыг тогтоох,
- ашигт малтмалын эрлийн болон хайгуулын үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн хуульчлах,
- хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник, эдийн засгийн үндэслэл, техникийн зураг төсөл, ордын үнэлгээг хийх арга аргачлалыг тодорхой болгох,
- хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх,
- ашигт малтмалын салбарын бодлого, төлөвлөлтийг сайжруулах,
- орлого, үр өгөөж, эдийн засгийн хүртээмжийг нэмэгдүүлэх,
- хэрэгжүүлэх арга хэмжээний зарчмыг тодорхойлох,
- уул уурхайн салбарын тогтолцоог тогтолцоог бэхжүүлэх болон

---

<sup>21</sup> Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтын Хүснэгт 2 тусгасан Иргэний үүсэх үйл ажиллагааны гүйцэтгэлийн цаг хугацааг тооцох зааварт холбогдох хугацааг заагаагүй байна.

- геологи, уул уурхайн асуудал хариуцсан салбар нэгжийг орон нутагт бий болгосноор төрийн байгууллага болон орон нутгийн хоорондын бодлого, шийдвэрийн уялдаа холбоог хангах,
- ашигт малтмалын салбарын үйл ажиллагаанд оролцогчдын чиг үүрэг, эрх зүйн байдалтай холбогдсон харилцааны үр өгөөжтэй байдлыг хангах чухал ач холбогдолтой.

Тооцооллоос үзэхэд энэхүү хүлээгдэж буй үр өгөөжтэй харьцуулахад үндсэн оролцогчид болох төрийн байгууллага болон хуулийн этгээдүүдэд томоохон хэмжээний нэмэгдэл зардал гарахгүй байна. Энэ хуулийн төслийг баталж хэрэгжүүлэх нь нийгэм, эдийн засагт ихээхэн ач холбогдолтой, ашигт малтмал, эрдэс баялгаас иргэн бүрийн хүртэх хүлээгдэж байгаа үр ашиг өндөр байгааг тэмдэглэх нь зүйтэй.



Хүснэгт 5. Иргэнд үүсэх зардлын задаргаа

Иргэн	Хуулийн төсөлд хамаарах зүйл, заалт	Хэрэгжүүлэх чиг үүрэг	Тохиолдол тоогоор /өдрөөр жилд хийх давтамж/	Зарцуулах хугацаа /минут/	Нийт зарцуулах хугацаа /минут/
<b>ИРГЭД</b>					
<b>Иргэн (Хэрэглэгч)</b>	Хуулийн төслийн 93 дугаар зүйлд заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлэх (93.4)	93.4.Иргэн, байгууллага, хуулийн этгээд нь шинжлэх ухаан, технологийн сан, олон улсын болон гадаадын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн хүрээнд бүрдүүлсэн геологи, уул уурхайн мэдээллийг геологи, эрдэс баялгийн мэдээллийн санд үнэ төлбөргүй төвлөрүүлэх үүрэгтэй.	Тоон хэмжүүрээр хэмжигдэх боломжгүй үйл ажиллагаанд хамаарна. Холбогдох зардал гарахгүй.		

---o0o---

